



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ногоон массын нягтралыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийтийн эзэмшлийн зарим гудамж, цэцэрлэгт болон орон сууцны хороолол дотор байгуулах "Ойн төгөл"-үүдэд 4-6 метрийн өндөртэй том оврын нарс модыг шилжүүлэн суулгах ажилд Төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавих, мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, тарилтын ажлын явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.


2. Том оврын нарс мод тарих байршил, тоо хэмжээ, зарцуулах хөрөнгийг хавсралт ёсоор баталсугай.

3. Мод шилжүүлэн суулгах ажлын зардал нийт 483.740.000 /Дөрвөн зуун наян гурван сая долоон зуун дөчин мянган/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2019 оны 09 сарын 29  
 өдрийн 11/11 тушаалын хавсралт



ХОТЫН ЗАРИМ ГУДАМЖ, ЦЭЦЭРЛЭГТ ТАРИХ  
 ТОМ ОВРЫН НАРС МОДНЫ  
 БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ, ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГӨ

Д.д	Мод тарих байршил	Тарих модны тоо /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1.	Баянзүрх дүүрэг. Энхтайваны өргөн чөлөө /Зүүн 4 замын уулзвараас Эскадрилын хөшөө хүртэл автозамын голын бульварт тарих/	685	380.000	260.300.000
	дүн	685		260.300.000
2.	Сонгинохайрхан /50ш/, Хан-уул /50ш/ дүүргийн орон сууцны хороолол дотор "Ойн төгөл" байгуулах, Халдвартын төв эмнэлгийн орчмыг ойжуулах	198	380.000	75.240.000
	дүн	198		75.240.000
3.	Наадамчдын зам дагууд урд талаар. Ц.Дамдинсүрэнгийн хөшөө орчим	190	380.000	72.200.000
	дүн	190		72.200.000
4.	Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргийн орон сууцны хороолол дотор "Ойн төгөл" байгуулах	200	380.000	76.000.000
	дүн	200		76.000.000
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1273</b>	<b>380.000</b>	<b>483.740.000</b>